

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2024/10/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр хот 2023 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173.
Утас/Факс: (976) 7032 3253.
Цахим шуудан: ovorkhangai@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хугацаа: 2023.12.15 №: 123
танай _____ -ны № _____ -г

АРВАЙХЭЭР ЦЭЦЭРЛЭГЖИЛТ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Д.МЯГМАР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ны үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл нь "Хот цэцэрлэгжүүлэлтийн цогц үйлчилгээ" бөгөөд тайлант онд орон нутгийн төсвөөс 516,884.0 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Энэ нь өмнөх оны санхүүжилтээс 120,000.0 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант оны хувьд нийтийн эзэмшлийн зам талбайд 5 төрлийн 19410 ш мод тарьж ногоон байгууламжийн талбайн хэмжээг 12.8 га -аар нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант үеийн санхүүгийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

015030061

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	378,403.5	417,752.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,676,080.9	3,698,782.8
	Нийт хөрөнгийн дүн	4,054,484.4	4,116,535.2
	Нийт өр төлбөрийн дүн	2,214.4	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,052,269.9	4,116,535.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,054,484.4	4,116,535.2
Санхүүгийн орлого үр дүнгийн тайлан			
	Борлуулалтын орлогын дүн	794,256.5	648,326.3
	Борлуулалтын өртөг	887,910.3	622,324.9
	Нийт ашиг алдагдал	(93,653.8)	26,001.4
	Татварын дараахь ашиг алдагдал	(93,653.8)	(285,644.7)
	Орлогын нийт үр дүн	(93,653.8)	(285,644.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Залруулсан үлдэгдэл	3,845,923.8	4,052,269.9
	Тайлант үеийн цэвэр ашиг	(93,653.8)	(285,644.7)
	Эцсийн үлдэгдэл	4,052,269.9	4,116,535.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	794,256.5	648,326.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	651,966.0	623,101.0
	Үйл ажиллагааны ЦМГ	142,290.5	25,225.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(153,261.5)	(16,409.9)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(10,971.0)	8,815.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	90,072.0	79,101.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	79,101.0	87,916.4

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.8 сая төгрөгийн алдааг залруулж, 22.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Залруулсан алдаа:

Тайлант хугацаанд илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн 60.9 мянган төгрөг, ХАОАТ-ын 715.3 мянган төгрөгийн авлагыг нягтлан бодох бүртгэлд авлагаар бүртгээгүй байсныг санхүүгийн тайланд залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан зарлагын 21702.5 мянган төгрөгийн зарлагын 3 гүйлгээг мэдээлээгүй, хуулийн 6.4.8-д заасан 760.0 мянган төгрөгийн 1 шийдвэрийн мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5

/мянган төгрөгөөр/								
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
шилэн дансны нэгдсэн цахим хуудаст зарлагын 3 гүйлгээ, төсөв, хөрөнгөтэй холбоотой 1 мэдээллийг байршуулаагүй	1	22,462.5			1	22,462.5		
Дүн	1	22,462.5	0	0	1	22,462.5	0	0
Бусад хувьл тогтоомжтой холбоотой зөрчил								

Дүн	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	1	22,462.5	0	0	0	1	22,462.5	0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143681
УИД 0050 9044094